

1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Боловсрол соёл, шинжилэх ухааны сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Аймгийн Засаг дарга БСШУ-ны салбарын сайдтай соёлын талаар 25, боловсролын талаар 28 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулан үндсэнд нь ханган нийлүүлж ажиллалаа.

Зуны цэцэрлэг, хувилбарт бүлгийн сургалт, явуулын багш ажиллуулж 1420 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрууллаа.

Гэрээг хэрэгжүүлж зохион байгуулсан арга хэмжээний дүнд цэцэрлэгийн хамран сургалт 3.0 хувь, хувилбарт сургалтын хамран сургалт 14.0 хувиар нэмэгдсэн бол бага боловсролынх 1,5 хувь, суурь боловсролынх 2.2 хувиар хамран сургалт нэмэгдлээ. . Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангамж 98.6 хувь болж өнгөрсөн оноос 3.8 хувиар ахилаа.

Соёл урлагийн салбараар үйлчлүүлэгсдийн нийт тоо нэмэгдэж мэргэжлийн боловсон хүчний хангамж нэмэгдэж түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт сайжирлаа.

Боловсролын соёлын салбарт 2009 онд хийгдэхээр төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд хугацаандаа бүрэн хийгдлээ.

2009 оны гэрээний биелэлтийг тооцож үзэхэд соёлын салбарын бүтээгдэхүүний нийлүүлэлт 96.8, боловсролын салбарын бүтээгдэхүүний нийлүүлэлт 92.0 хувьтай нийт дүнгээрээ 94.4 хувьтай биелэгдлээ.

Булган сумын 4 дүгээр цэцэрлэг Улсын тэргүүний цэцэрлэгийн болзлыг хангаж, цолоо хүртлээ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Аймгийн Засаг дарга НХХ-ийн сайд нарын хооронд 44 бүтээгдэхүүн нийлүүлэх болон санхүүжүүлэх гэрээ байгуулан ажиллалаа.

Ядуу, нэн ядуу өрхүүдээс сонголт хийж, нийт 338 өрхийг “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-т хамрууллаа.

Нийгмийн хамгааллын бүртгэл мэдээллийн санг бүх сумдад байгуулж, ХХҮХ-ийн мэргэжилтнүүдийг “not book”-тэй болгож Халамж үйлчилгээний программ /“ХҮМ”/-аар халамжийн тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн тэтгэмж, шинэ гэр бүлд олгох нэг удаагийн тэтгэмжийг олгож эхэллээ.

Аймгийн ЗДТГ, Дэлхийн зөн ОУБ –тай иргэдийг малжуулах асуудлаар гэрээ байгуулан Булган нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс малжуулах төсөл хэрэгжүүлж Булган сумын 21 өрхөд 840 мал, Хангал, Хялганат, Орхон, Хишиг-Өндөр сумын 28 өрхөд 1120 мал олголоо. Мөн Булган хангай нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс малжуулах төсөл хэрэгжүүлж 100 өрхөд 2850 гаруй мал олгов. ХЯБХХН-ийн төслөөр аймгийн үржлийн алба болон 5 сумын цөөн малтай 81 өрхөд 66.4 сая төгрөгийн сайн үүлдрийн мал өглөө.

Өрхийн орлогийг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 232.5 сая төгрөг, ХЭДСангаас 540.0 сая төгрөгний эх үүсвэрийг арилжааны банкууд болон “Актевинвест” ББС байгууллагуудад

байршуулж, сумдад 5.0-10.0 сая төгрөгийг байршуулж 163 төсөлд 158.2 сая төгрөгний зээл олгож 252 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

2009 онд бүх сумдаас олон нийтийн санаачлагад тулгуурлан боловсрол, соёл, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин болон бусад нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг сайжруулах чиглэлээр Тогтвортой амьжиргаа-2 төслөөс нийт 57 төсөл хэрэгжиж 200.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ.

Байгалийн гамшгийн улмаас орон гэргүй болсон иргэдэд гэр орон сууц авахад нь зориулж тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх, гэр оронгүй иргэдэд гэр өгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар сумдад 30 гэр олгоод байна. Дэлхийн зөн ОУБ-ын Булган нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 6 өрхөд гэр олголоо. Булганхангай нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс 5 иргэнд гэр олгож, Дашинчилэнд 14, Бүрэгхангайд 6, нийт 20 өрхийг байшинтай болголоо.

Аймгийн ЗДТГ, Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “Манлайлагч эмэгтэйчүүд” чуулга уулзалтыг зохион байгуулж, “Аймгийн эмэгтэйчүүдийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай” ЗД-ын илтгэл, эмэгтэйчүүд –эрүүл мэнд, хүүхдийн хөгжилд эцэг эхийн үүрэг, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал-хөдөлмөр эрхлэлтийг өнөөгийн байдал зэрэг 5 дэд илтгэл хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч, 9-н “Тэнгэрлэг гэр бүл” –ийг шалгарууллаа.

Ахмадын зуны амралтыг 6- 8-р сард 8 ээлжинд 160 ахмадуудыг амрааж, одоо өвлийн амралтанд 6 дахь ээлжээ авч байна.

Нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан гэрээг 90.0 хувийн биелэлттэй хэрэгжүүллээ.

Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Аймгийн Засаг дарга, ЭМ-ийн сайдтай 5 нэрийн 41 бүтээгдэхүүн нийлүүлхээр гэрээ байгуулан ажиллаж, гэрээний биелэлт 80.0 хувьтай дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх болон санхүүжүүлэх гэрээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийг авч үзэхэд тухайн жилд эхийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдэж, 0-5насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 21.3 байгаа нь улсын дундажаас 1000 амьд төрөлтөнд 2.2 промилоор бага байна. Нийт халдварт өвчний тоо өнгөрсөн оныхоос 91 тохиолдлоор буурсан боловч 10000 хүн амд улс аймгийн дундажаас 20 промилоор өндөр байна

Аймгийн хэмжээнд эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах чиглэлээр олон арга хэмжээнүүдийг зохион байгуулан, өвчлөл эндэгдлийн шалтгааныг судлан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, “Эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөө”г батлуулан хэрэгжүүлж байна.

Сум, сум дундын эмнэлэг, өрхийн эмнэлгийг нэн шаардлагатай байгаа оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмжийн судалгааг гаргаж, бүх сумдыг лабораторийн багажаар хангаж, аймгийн Нэгдсэн эмнэлгийг нэн шаардлагатай байгаа 17 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр ханган, лабораторийн тасагт шээс цусны шинжилгээ хийх “Элиза” аппаратыг суурилуулж, 2 лаборантыг нарийн мэргэжлийн сургалтад хамрууллаа.

Хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх талаар анхаарч, аймгийн нийт хүн амыг бие бялдрын сорилд хамруулах, өвчлөлийг бууруулах талаар ажлуудыг зохион байгуулсны үр

дүнд биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг өдөр тутмын хэрэглээ болгох, ажиллаж амьдрах чадамжийг сайжруулж дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байранд хийх дасгал хөдөлгөөний жорыг бэлтгэж албан байгууллага аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн 60 гаруй байгууллагад өдрийн гимнастик ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж гарын авлага тараах материалыг цувралаар гарган тарааж, аймгийн хэмжээнд 35065 хүн сорил судалгаанд хамрагдлаа.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээг өргөжүүлэх тухай Засгийн газрын 2008 оны 05 тоот тогтоолын дагуу “Биеийн тамир- эрүүл мэнд” уриан дор “Аялах дэвтэр”-ийг аялуулж, сар бүр нэрэмжит ажлыг зохион байгуулж оны эцэст дүгнэлээ.

“Хүн бүр өөртөө 30 минут зориулцгаая” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амын бие бялдрын хөгжүүлэх биеийн тамир идвэхтэй дасгал хөдөлгөөнийг өдөр тутмын хэрэглээ болгосноор халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж амьдрах чадамжийг сайжруулж дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг идвэхтэй зохион байгуулан албан байгууллага аж ахуй нэгж хувийн хэвшлийн 60 гаруй байгууллагад өдрийн гимнастик, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж гарын авлага тараах материал, хөдөлгөөний жорыг бэлтгэн БТСГ-с эрхлэн гаргадаг “Спортын мэдээ” бичил сониноор цуврал болгон гаргаж байна.

Хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх талаар анхаарч аймгийн нийт хүн амыг бие бялдрын сорилд хамруулах, өвчлөлийг бууруулах талаар ажлуудыг зохион байгуулан аймгийн хэмжээнд 35065 хүн Бие бялдрын түвшин тогтоох сорил судалгаанд хамрууллаа.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Хүнс, Хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг дарга 92 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулж 88 асуудал биелэгдэж, 4 асуудал хагас биелэж хэрэгжилт 92,4 хувийн биелэлттэй байна.

Мал сүрэг 2.6 сая толгойд хүрч 5 төрөл дээр өсөн өмнөх оноос 8.1 хувь буюу 197.5 мянган толгойгоор нэмэгдэж, хураан авсан ургацын хэмжээ өмнөх оноос үр тариа 9,3 хувь, хүнсний ногоо 19 хувь, жимс, жимсгэнэ 90 хувь, уринш боловсруулат 16 хувь өсөж га-аас дундажаар 18.3 цн үр тариа хураасан нь 2008 оны нэгжийн ургацаас 2.7 цн илүү байна. Усалгаатай тарилангийн хэмжээ 1800 га-д хүрч өмнөх жилээс 500 га-аар нэмэгдэж, Эрдэнэт үйлдвэрийн паркттай хамтарсан үйлдвэрлэл үйлчилгээний газар нээх, Рашаант суманд малын тэжээлийн цех, Булган сумын төвд сүү боловсруулах жижиг үйлдвэр мөн мал нядалгааны төвлөрсөн цэг байгуулах, Сэлэнгэ, Хутаг–Өндөр сумдад таримал ургамлын сортын үр үржүүлэх нэгж бий болгох зэрэг асуудал тасарсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтын гэрээгээр 4 бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хүлээж, 91,5 хувь биелүүлж ажиллалаа.

Газрын батлагдсан төсөв 599 сая, 911.1 мянган төгрөг тусгагдсанаас 485 сая, 899.5 төгрөгийн санхүүжилт олгогдож, 485 сая 195.7 мянган төгрөг зарцуулж, 703.8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, 361 га ойжуулалт, 130 га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг хийж, 79-88 хувийн амьдралттайгаар улсын комисс хүлээлгэж өглөө.

5 сумын нутагт 8 булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг сонгон шалгаруулалтанд ялалт байгуулсан 3 төрийн бус байгууллагаар гүйцэтгүүллээ.

Хуурайшилт ихсэж ой хээрийн түймэр гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан ой, хээрт аялах, жуулчлах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах үйл ажиллагааг 2009 оны 4-р сарын 20-оос 6-р сарын 10-ны хооронд хориглох арга хэмжээ авах тухай аймгийн Засаг даргын 2009 оны 122 дугаар захирамж гаргуулан сумдад хүргүүлэн мөрдлөг болгон ажилласан.

Аймгийн ИТХ-аар модны жишиг үнийг тогтоолгон албан байгууллага, ард иргэддээ хямд сайн чанарын модоор хангаж ажилласны дүнд айл өрх нь чацаргана, үхрийн нүд, албан газрууд нь гаднах үзэмжиндээ анхаарч цэцэрлэгжүүлэлтийн хайлаас, шар хуайс зэрэг нийт 20658 ширхэг модыг шинээр тарьж, 2714.65 м2 газрыг зүлэгжүүллээ.

Усны тоо бүртгэлийн ажлыг явуулан мэдээг улсын усны мэдээллийн санд оруулсан. 2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 469 гол, горхи тоологдсоны 76 нь, 620 булаг, шанд тоологдсоны 228 нь, 106 нуур, тойром тоологдсоны 32 нь, 50 рашаан тоологдсоны 2 нь ширгэсэн байна. Мөн 279 өрөмдмөл худаг, 205 богино яндант худаг, 236 бетон хашлагат худаг, 212 энгийн уурхайн худаг, нийт 932 худаг тоологдлоо.

Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:

Батлан хамгаалахын Сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ, дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний анги байгууллага дээр хийсэн тодотголын мөрөөр нэн шаардлагатай байгаа мэргэжлүүдээр дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний 14 хоногийн сургалтыг Булган аймгийн “Цэргийн үүрэгтэний сургалтын төв”-д зохион байгуулан явууллаа.

Сургалтыг 05-р сарын 26-аас 06-р сарын 08 -ны өдрүүдэд зохион байгуулж, цэргийн үүрэгтэн 40 хүнийг мотобуудлагын тагнуулчин, бууны дарга, химийн цэвэрлэгч, артиллерийн тагнуулчин гэсэн 4 мэргэжлээр шинээр шилжүүлэн мэргэжил эзэмшүүлж, дайчилгааны даалгавар бүхий анги байгууллагын шаардлагатай командуудад оногдуулан дансаллаа.

Сургалтыг цэргийн штабын ажилтанууд удирдан зохион байгуулж ЗХ-ний 186-р ангийн зэвсэг, багаж хэрэгсэл үзүүлэн таниулах материалыг түшиглэн тус ангийн мэргэжлийн багш офицеруудаар хичээл заалгалаа.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдийн сургалтыг 14 хоногийн хугацаатай зохион байгуулж уг сургалтанд 58 иргэнийг хамрууллаа. Монгол улсад үндэсний Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны 88 жилийн ойг Булган аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб, Цэрэг татлагын товчоо тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлж Батлан хамгаалах талаар төр, засгаас явуулж буй бодлого чиглэл, Батлан хамгаалахын холбогдолтой хууль тогтоомжуудыг ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, ЕБС-ийн сурагчдад сурталчлах ажлыг өргөн далайцтай зохион байгууллаа.

Ойн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Батлан хамгаалах хууль, Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль,


Зэвсэгт хүчний түүхэн замналыг орон нутгийн телевиз, сонин, мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан сум, орон нутаг, ард иргэдэд сурталчиллаа. Эдгээр ажлыг хийсний үр дүнд Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 92,5 хувьтай биелэлээ.

Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлж:


Хууль зүй дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээгээр удирдлага зохион байгуулалт, Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээг төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлж, нийт 559,4 сая төгрөгийн санхүүжилт авч ажиллаа.

Булган аймгийн хэмжээнд 2009 оны байдлаар 289 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 хэргээр буюу 3.2 хувиар өссөн статистик гарлаа.

Гэмт хэргийн гаралт



Гэмт хэргийн илрүүлэлт



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн илрүүлэлт 66.6 хувь байгаа нь өнгөрсөн оноос 100.0 хувиар өсөв. Энэ нь ЦЕГ-аас дэвшүүлсэн гэмт хэргийн илрүүлэлтийг хөдөө, орон нутагт 60.0 хувьд хүргэнэ гэсэн зорилтоос 6.6 хувиар илүү байна. Илрээгүй хэрэг өнгөрсөн онд 16 байсан бол энэ онд 7 гэмт хэрэг байгаа нь 56.3 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 91 буюу 31.4 хувь нь хөнгөн, 168 буюу 58.1 хувь хүндэвтэр, 22 буюу 7.6 хувь хүнд, 8 буюу 2.7 хувь онц хүнд гэмт хэрэг байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзвэл 1.3 хувийг бусдыг санаатай алах гэмт хэрэг, 19.7 хувийг иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 0.3 бусдыг хүчиндэх гэмт хэрэг, 42.2 бусдыг өмчийг хулгайлах гэмт хэрэг, 7.6 хувийг ашиглал, албан тушаалын гэмт хэрэг, 3.1 хувийг танхайрах гэмт хэрэг, 6.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалын журмын эсрэг гэмт хэрэг, мөн 1.3 хувийг бусдыг дээрэмдэх, бусдын өмчийг булаах гэмт хэрэг, 7.9 хувийг байгаль орчны эсрэг гэмт хэрэг, 9.6 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна байна.

Гэмт хэргийн улмаас 243 иргэн хохирсны 56 буюу 23.0 хувь нь эмэгтэй, 11 буюу 4.5 хувь насанд хүрээгүй хүүхэд, 43 буюу 17.9 хувь тодорхой эрхэлсэн ажилгүй хүн, 95 буюу 39.0 хувь нь малчин хүмүүс байна.

Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 503.6 сая төгрөгийн хохирол учирсны 342.9 сая төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн нь хохирлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 2.2 дахин, нөхөн төлүүлэлт 3 дахин өссөн байна.

Нийт хохирлын 68.0 хувийг нөхөн төлүүлсэн нь энэ онд ЦЕГ-аас дэвшүүлсэн нийт учирсан хохирлын 60.0 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж иргэний нэхэмжлэлийг хангана гэсэн зорилтын хүрэх ёстой түвшингээс 8.0 хувиар илүү байна.

Эдгээр ажлын үр дүнд Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 94,5 хувьтай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР